

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны ... дугаар  
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

## Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Хэнтий-Ус” ХХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 74 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Хэрлэн сум, Батноров сумын Бэрх тосгоны хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Хэнтий-Ус” ХХК /Г.Батгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Болор-Эрдэнэ/-д даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 65 дугаар тогтоол, 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 525 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

## ГАРЫН ҮСЭГ

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

П.ТОВУУДОРЖ

ЗОХИЦУУЛАГЧ

Л.ДАШМЯГМАРЖАВ

ЗОХИЦУУЛАГЧ

Ц.НОРОВЖАМЦ

ЗОХИЦУУЛАГЧ

Д.ЦОГОО

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМ БОЛОН БАТНОРОВ СУМЫН  
БЭРХ ТОСГОНЫ ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ  
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Хэнтий аймгийн Хэрлэн сум, Батноров сумын Бэрх тосгоны хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:  
Үүнд:

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөв болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	1,900.0
2	Төсөв болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ 32,444.6
		тогтмол	Төг/м <sup>3</sup> 1,040.3
3	Төсөв болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээний ус халаасан дулаан	Төг/м <sup>3</sup>	4,000.0
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м <sup>2</sup>	1,000.0
5	Ахуйн хэрэгцээний ус халаасан дулаан	Төг/м <sup>3</sup>	4,000.0
6	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	Төг/сар 3,000.0
		41-81 м <sup>2</sup> талбайтай айл өрх	Төг/сар 5,000.0
		81 м <sup>2</sup> –с дээш талбайтай айл өрх	Төг/сар 10,000.0